

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVIII (412)

2014

(133-148)

Жамсрангийн Цэвээн гэж хэн байв?

Б. Шагдаржав¹³⁰

Хураангуй: Нэрт эрдэмтэн Ж.Цэвээн ий шинэ монголын нам төр, боловсрол, шинжлэх ухаан, сэтгүүлзүй болон нийгмийн олон салбарт оруулсан хувь нэмэр, хөдөлмөр гавьяаг энэ өгүүлэлд нэгтгэн гаргахыг хичээсэн болно.

Түлхүүр үг: *Эрдэм ухаан, эх оронч сэтгэл, хичээл зүтгэл, үүсгэл санаачилга*

Товч намтар

20-р зууны эхэн үед Монгол улсын мандал бадралын төлөө нэгэн биеийн алжаалыг үл хайхран хоёргүй сэтгэлээр махран зүтгэж, нэрээ мөнхлөх гавьяат үйл бүтээсэн хүмүүсийн нэг нь төр, нийгмийн зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, нэрт эрдэмтэн Жамсрангийн Цэвээн болой.

Ж.Цэвээн 1881 оны 4сарын 26-нд одоогийн ОХУ-ын Чита мужийн Ага голын эрэг дагуух Сүдэнт нутагт шарайд омгийн айлд мэндэлжээ. 1891 онд Чита хотын бага сургуульд элсэн эрдэм номын мөрөө эхэлсэн байна. Уг сургуулиа төгсөөд Петербург хотод, Буриадын нөлөө бүхий сэхээтэн Бадмаевын байгуулсан дунд сургуульд дэвшин суралцсан боловч уг сургууль нь дээдсийн шахалтаар хаагдсан тул нутагтаа эргэж ирэн Эрхүү хотын багшийн сургуульд үргэлжлүүлэн суралцсан байна. 1901 онд төгсөөд уг сургуульдаа багшилсан тэр үеэс эрдэм судлалын их ажлаа эхэлжээ.

1902 онд Петербургийн их сургуульд элссэн бөгөөд сургалтын төлбөрийг төрсөн нутаг Агын хурал гаргаж байсан нь эрдэм номын албаа хичээнгүй сайн хийх эрч хүч өгчээ. 1907 оноос уг сургуульдаа монгол хэлний багшаар ажилласан байна. Оюутан байхдаа ч багш болсон хойноо ч монгол хэл, аман зохиол, угсаатны зүйн судалгааны ангийн эрдэмтэдтэй хамт Байгал нуур, Халх Монгол, Хөлөнбуйр, Ордос, Хөх нуур, Тагна, Тува зэрэг олон газар орноор явж эрдэм шинжилгээний баялаг материал цуглуулжээ.

¹³⁰ Сити дээд сургууль

1911 онд Ж.Цэвээн Их Хүрээнд байх Оросын консулын газрын зөвлөхөөр томилогдсон байна. Энэ үеэс элгэн садан монголчуудынхаа өсөн дэвжих үйл хэргийн төлөө үнэнхүү сэтгэлээр зүтгэн, Богд гэгээний засгийн газарт боловсрол эрхэлсэн зөвлөхөөр ажиллаж байлаа. Олон түмнийг гэгээрүүлэхэд сургууль, ном, хэвлэлийн үүрэг чухал гэдгийг сайтар ойлгодог Ж.Цэвээн ий үүсгэл, санаачилгаар 1912-1915 онуудад иргэний, төрийн, анхны бага сургууль байгуулагдан, анхны тогтмол хэвлэлүүд гарч эхэлжээ.

1917 онд гарсан Октябрийн хувьсгалын үйл хэрэгт гар, бие оролцохоор нутаг буцсан байна. 1917 оноос эхлэн Байгалийн наадах буриадуудын улс төрийн амьдралд идэвхтэй оролцон, олон ажил үүрэг гүйцэтгэж, буриадын ард түмний тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн гол удирдагч, онолч нарын нэг байв. 1919 оноос Эрхүүгийн их сургуульд багшилж байхдаа ч Монголтой байнга холбоотой хэвээр ирж, очиж байсан баримт бий.

1920 оноос Монголын хувьсгалчидтай ойр дотно байж, тэдний анд нөхөр, туслагч, зөвлөгч нь болж байсан юм. МАН-ын анхны их хуралд гишүүнээр оролцон, намынхаа анхны мөрийн хөтөлбөрийг гардан боловсруулсан түүхэн гавьяатай.

1921 оноос Коминтерний төлөөлөгчөөр Монголд томилогдон, нам төр, соёл боловсрол, шинжлэх ухааны үйл хэрэгт идэвх санаачилгатай ажиллаж эхэлсэн юм. Тухайн үедээ мэдлэг боловсрол, улс төрийн ажлын туршлагаар нөхдөөсөө илүү байсны ачаар илүү алсыг харж, Монголын хөгжилд тустай олон ажил эхлүүлснийхээ төлөө 1928 оноос эхлэн элдэв нэр хоч зүүн, бүдүүлэг цагийн эрхээр “баруунтан-буруутан” болж явсан нь гашуун үнэн болно.

1932-1937 онуудад Ленинград хотноо ЗСБНХУ-ын ШУА-ын Дорно дахины хүрээлэнд ажиллан, анхнаас зорьсон эрдэм судлалын ажлаа үргэлжлүүлэн хийх болов. Монгол судлалын ажилд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн 1936 онд хэл шинжлэлийн ухааны доктор цол, ЗСБНХУ-ын ШУА-ын сурвалжлагч гишүүнээр сонгосон байна. Петербургийн их сургуулийн анхны буриад төгсөгч, орчин цагийн шинжлэх ухааны ийм өндөр цол хүртсэн анхны монгол хүн байх түүхэн хувь тохиол түүнд оногджээ.

Улс төрийн амьдралын зөв байр сууринаасаа болж 1937-8-10-д баривчлагдан 1942-4-14-нд Оренбург мужийн Соль-Елецкийн шоронд нас барсан. 1962-2-16-нд ЗХУ-ын Дээд шүүх хилс хэргээс цагаатгажээ.

1911 оны үндэсний анхдугаар хувьсгалын үйл хэргийн төлөө

Монголын эх оронч үзэлтэй лам ноёд, сэхээтнүүдийн санаачилга, Богд Жавзандамба хутагтын шууд дэмжлэг, өргөн олны оролцоотойгоор ялсан үндэсний анхдугаар хувьсгалын бодит үр дүн нь монгол туургатны үндэсний эрх чөлөөгөө мандуулах чин хүслийг бадрааж, хоорондоо ойртон нягтрах үзэл санаа бүрэлдэхэд онцгой нөлөө үзүүлсэн юм.

Энэ эгзэгтэй үед "...Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал ид өрнөн ялах үеэр, 1911 оны эцсээр Монголд цаг мөч алдалгүй яаравчлан ирж. "/2-5/ өөрийн олон талт үйл ажиллагаагаа эхэлжээ. Олон хэл мэддэг, өндөр боловсролтой хүн байсан тул нийгмийн өргөн давхарга, дээд зиндааны хүмүүсийн дунд дорхноо нэр хүнд олж, өөрийн байр суурийг эзэлсэн билээ. Богд Жавзандамба хутагт болон Ерөнхий сайд, Гадаад явдлын яамны сайд нарын шадар түшмэл болж, Оросын хаанд явуулах төрийн албан бичгүүдийг орос хэлээр бэлтгэж байлаа. 1913 оны өвөл Оросын хаанд бараалхах Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн, Гадаад явдлын яамны сайд чин ван Ханддорж нарын тэргүүлсэн Монголын төлөөлөгчдийн, 1915 онд Хиагтад болсон гурван улсын хэлэлцээрт оролцох төлөөлөгчдийн бүрэлдхүүнд тус тус багтан эх зохиогч, хэлмэрчээр ажиллаж байв.

Богд хаанд туурга тусгаар улс өөрийн одон тэмдэгтэй байхын учир утгыг ухуулан ойлгуулж чадсаны хүчинд 1913 оны эхээр буриад хамба Агваандоржийг Петербург хотноо илгээж, монгол төрийн анхны одон болох "Эрдэнийн очир" одонг захиалан хийлгүүлжээ.

Гурван улсын хэлэлцээрээр Монголын автономит эрхийг үгүй хийсэн тул өөр арга зам хайхад хүргэсэн юм. "...Ялангуяа Ж.Цэвээн ...нарын зэрэг буриадын сэхээтнүүд гадаад дотоод Монгол, Буриад, Шинжааны Монголчууд, Тува-г нэгтгэсэн их Монгол улсыг байгуулах үзэл санааг дэвшүүлж...Орос, Хятадын бүрэлдхүүнд автономит эрхтэй байж, Монголын асуудлыг бүрэн шийдэж чадахгүй нь тодорхой бөгөөд харин монгол угсаатны автономит мужуудаас бүрэлдсэн, нэгдсэн Монгол улсыг байгуулах нь Монголын асуудлыг шийдэх арга зам ..." /3-85/ гэж үзэж байжээ.

"...Энэхүү хөдөлгөөн нь ...Монгол үндэстний ард түмнийг эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэлд уриалан, монгол сэхээтнүүдийн дунд нэг үе дэвшилт санааны нөлөө үзүүлж, манай үндэсний тусгаар тогтнолын ардчилсан хөдөлгөөнд үр цацаж..." /1-58/ нэгдэн тэмцэж эрх чөлөөгөө олох гэсэн үзэл бүрэлдэхэд зохих ёсоор нөлөөлсөн билээ. Энэ үзэл санаа нь Монголчуудын язгуур эрх ашигт тохирч байсан боловч их гүрнүүдийн төрийн бодлого, ашиг сонирхлын улмаас биелэх боломжгүй байсан нь харамсалтай.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал, нам, төрийн үйлсэд

1920 оноос эхлэн Монголын хувьсгалчидтай танилцан хамтран ажиллаж, тэдний үйл хэрэгт өөрийн боломжоор тусалж байв. 1921 оны 3 сарын 01 нд Хиагт хотноо Монголын 26 хувьсгалч өөрийн улс төрийн намын анхны хурлаа хийсэн ба тэдний дотор Ж.Цэвээн гэргий Сахьяагийн Бадамжавын хамт байсан нь түүхийн бичигт тэмдэглэгдэн үлджээ. Хурлаар улс төрийн намынхаа мөрдөх журам болсон “Түмэнд тунхаглан зарлах бичиг”-ийг хэлэлцэн баталсан байна. Ийнхүү “...хуралд намын гишүүн 26 хүн оролцож Ж.Цэвээн ий боловсруулсан “МАН-аас түмэнд тунхаглан зарлах бичиг”-ийг хэлэлцэж, нэлээд санал гарган, бага сага засамжлан батлахад” /3-116/ нь улс төрийн ажлын нэлээдгүй туршлага суусан Ж.Цэвээн ий оролцоо голлох үүрэгтэй байсан юм.

“...Ж.Цэвээн ардын намын анхны мөрийн хөтөлбөр болох “Түмэнд тунхаглан зарлах бичиг”-ийг зохиожээ. Ганцхан энэ гавьяа нь л гэхэд Монголын түүхэнд түүнийг мөнхлөхөд хангалттай юм. Тэр үед Ж.Цэвээн журмын нөхдийнхөө дотор том онолч, манлайлагч болон тодорч байсан гэх үндэс бий...” /4-22/ гэсэн нь үнэнд нийцэх бөгөөд улс төрийн ажлын туршлага, нийгэм түүхийн онол, гадаад хэлний мэдлэгээрээ журмын нөхдөөсөө илүү байсан гэдэгтэй маргах хүн гарахгүй байх.

1921 оны хувьсгалын үйл хэрэгт анхнаас нь голлох үүрэгтэй оролцож явсан, өндөр боловсролтой, холын хараатай энэ хүн эл хувьсгалын түүхийг хуучраагүй байгаа дээр нь ямар нэгэн засваргүйгээр түүхэн үнэнээр нь үлдээх учиртайг ойлгож,” Монгол дахь хувьсгалт үйл хэргийн товч түүх” гэдэг номоо 1926 онд бичиж хэвлүүлсэн байна. “... Ж.Цэвээн тэр үеийн үйл явдлыг нүдээр үзэж, түүнд гар бие оролцож байсныхаа хувьд түүхэн баримтыг нэгтгэн, шинэ Монголын түүхэнд анх удаа энэ сэдвээр ном бичиж хэвлүүлснээрээ хойч үеийнхэндээ хүндлэгдэх гавьяатай хүн билээ...” /4-23/ гэсэн нь хожмын түүхчдэд хосгүй үнэтэй эх сурвалж бичиж үлдээснийг үнэлж буй хэрэг юм.

Ж.Цэвээний бас нэгэн томоохон гавьяа бол Монгол улсын анхны үндсэн хуулийг боловсруулахад оруулсан хувь нэмэр юм. “Үндсэн хууль боловсруулах комиссыг анх 1922 оны 5-р сарын 19-нд Шүүх яамны сайд Н.Магсаржав, Ж.Цэвээн, Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй байгуулж... Англи, Швед, Бельги, Голланд зэрэг орны үндсэн хууль ба үндсэн хуулийн чанартай актууд, тэдгээртэй холбоотой бичиг зохиолыг орчуулан үлгэр загвар авч... Монгол төрийн зүтгэлтнүүд өөрийн орны онцлог, түүхэн уламжлал, олон улсын жишгийг харгалзан төслийг боловсруулж их хуралд оруулахаар бэлтгэсэн” /3-152/ бөгөөд Ж.Цэвээн Европын дээрх орнууд болон Америкийн үндсэн хууль, бусад баримт актуудыг тухайн хэлнээс нь эх хэлнээ хөрвүүлсэн гол хүн нь байж, өөрийн орны байдалд тохируулан, засамжлан найруулахыг бусад нөхөдтэйгээ зөвшилцөн бичсэн бөгөөд энэ хууль нь дараа дараагийн хуулиуд, эрх зүйн баримт бичгийн монгол эх сурвалж болж чадсан билээ.

Тэрээр “Төрийн эрх”, “Монгол улсын хурал ба ардын засгийн тухай” зэрэг олон өгүүлэл бичсэн ба тэдгээр өгүүллийн үзэл санаа нь шинэ тутам байгуулагдсан ардын төр үйл ажлаа зөв хөтлөн явуулахад зохих нөлөө үзүүлсэн болно. Эдгээр өгүүллийн үзэл санаа одоо ч хуучраагүй байгааг хэлэх хэрэгтэй.

Ялсан хувьсгалын үйл хэргийг үргэлжлүүлж, шинэ Монголын нам, төрийн олон олон алба хашиж, бие, сэтгэл чилэхийг үл харгалзан зөвхөн голч, үнэн журмыг барин

зүтгэсэн билээ. Тэрээр Түр Засгийн газрын Дотоод явдлын яамны дэд сайд, Цэргийн зөвлөлийн гишүүн, Цэргийн яамны төв хэлтсийн хариуцлагатай ажилтан, Улсын банкны зөвлөлийн гишүүн, Судар бичгийн хүрээлэнгийн эрлэмтэн нарийн бичгийн дарга, Ардыг гэгээрүүлэх яамны зөвлөх түшмэл, Намын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн, Улсын Бага Хурлын гишүүн, МАХН-ын ТХ-ны дэргэдэх шашны хэрэг эрхлэх тусгай комиссын гишүүн, МАХН-ын хянан шалгах төв комиссын дарга зэрэг алба хашин, ажилласан салбар бүрийнхээ эх суурийг тавилцаж, дүрэм журмыг боловсруулж, цаашдын зам мөрийг нь засаж, засалцаж явсан билээ.

Б.Цэрэндорж, Ж.Цэвээн нарын зэрэг хүмүүс ёстой л “Ахуй төр минь бүү алдартугай” хэмээн ажиллаж байсан ч “...Чин үнэнчээр зүтгэж, үзэл баримтлалаа авч үлдэхийн төлөө ихээхэн ухаалаг бодлого, үйл ажиллагаа -явуулахад хүрсэн” /3-148/ тийм цаг монгол төрд ирсэн юм. Коминтерний удирдлагад байсан зарим хүний байр суурь, хагаралдуулах бодлогын харгайгаар нам, төрийн эрх барьж байсан хүмүүс хоорондоо зөрчилдөн, буруу нь зөвөө ялласан, бурангуй бодлогын золиос болсон “баруунтнуудын” нэг нь Ж.Цэвээн байв.

Ялангуяа Ж.Цэвээн ий төвийг сахих бодлого Коминтерний зарим хүмүүст таалагдаагүй учир, үзэл бодол нэгт нөхдийн хамт “буруутан” болж, Зөвлөлтийг шууд хурдавчлан хуулбарласан, цагаа олоогүй бодлого тухайн үеийн нам, төрийн баримтлах чиг шугам болсон билээ. Өнөөдөр эргэн харахад, “...Ийнхүү төвийг сахих бодлого явуулах нь Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ач тустай байсан байж болохыг өнгөрсөн түүх нотлон харуулж” /3-163/ байгааг ч бодолцох хэрэгтэй байж магадгүй

Ж.Цэвээн бол үндэсний ардчилсан үзэлдээ үнэнч байж, өөрийн үйл хэрэг, үзэл бодлоо хамгаалан тэмцдэг, төрт ёсны уламжлалыг хүндтгэн сахидаг, 20-р зууны эхэн үеийн Монголын төр, МАН-ын томоохон зүтгэлтэн байв.

Монгол оронд шинжлэх ухааны сургуулийг үүсгэн санаачлагч мөн

Автономит Монголын үед

1911 онд Ж.Цэвээн Их Хүрээнд байгаа, Орос улсын консулын газрын зөвлөхөөр томилогдсон тэр цагас эхлэн элгэн садан Монголчуудынхаа харанхуй бүдүүлэг байдлыг хэрхэн арилгах, бичиг үсэгт сургаж соёл боловсролыг нь хэрхэн хөгжүүлэх талаар санаа тавьж байсан ба энэ үед Богдын засгийн газарт боловсрол эрхэлсэн зөвлөхөөр ажиллуулах хүсэлтийг баяртай хүлээн авсан билээ.

Судлан шинжлэх ажлын их туршлагатай, байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй хүн байсан тул нэг их удалгүй Монгол оронд боловсролын шинэтгэл хийх хөтөлбөр, бага, дунд сургуулийн анхны дүрэм зохиож Засгийн газарт өргөн мэдүүлсэн байна. Тэрхүү боловсролын шинэтгэл хийх хөтөлбөртөө:

“Орос, Франц, Англи зэрэг орнуудын жишгээр одоо цагийн бага, дунд, дээд сургууль байгуулж, тэнд эх хэл, тоо бодлого, газар зүй, бодисын зүй, хувилах ухаан, гадаадын хийгээд өөрийн орны түүх, бусад шинжлэх ухааныг заах, хажуугаар нь цэргийн хэрэг, аж үйлдвэр, газар тариалан, мал аж ахуй, анагаах ухаан зэрэг салбарын мэргэжилтэн бэлтгэх төрөлжсөн сургуулиудыг байгуулан тэдгээрт орос, англи, хятад, манж бичгийг заан сургаж, бүх хичээлийг монгол дээр сурагчийг бэлтгэж байх явдал чухал” /3-40/ гэж бичсэн байна.

Чин ван Ханддоржид 1912-3-30-нд мэдүүлсэн “Төрийн сургууль байгуулах тухай Автономитын Гадаад яаманд өргөсөн төслийн бичиг”-тээ “Гадаадын олон хүчирхэг улсын хамаг чадал нь гагцхүү элдэв ухааны эрдэмд нэвтрэлцэн дээд доод эр эм ялгахгүй цөм бага наснаас эхлэн хэрээр адаг, дунд, их гурван зэргийн сургуулиар явж, зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэлээр судалснаар энэ мэт хүчирхэг болжээ” /5-11/ хэмээн улс орны хөгжихийн үндэс нь боловсрол байдаг болохыг ухуулжээ. Хамгийн түрүүнд бага сургууль байгуулахыг чухалчилж “Учир иймийн тул хүсэх нь,

Нэгэн зүйл. Да Хүрээ Монгол улсын нийслэл хот, олон түмний төв газар болж тогтсон тул, энд дав дээр доорд сургууль нэгийг байгуулж, хожмоо дундад сургууль нэмэхээр сууриа тавьж дурсагдсан олон ухаанд багачуудыг сургахыг эрсүгэй. Гадаадын харь хэлнээс, Орос, Хятад хоёр хэлийг сурагчдын авьяас дураар сонгож үзүүлбээс зохимой”/5-13/ хэмээн бичсэн байна.

Өмнө нь өөр хүмүүсээс Богдод айлтгасан бичиг, Дотоод яамнаас Сангийн яаманд илгээсэн бичиг зэрэгт язгууртны хүүхдийг сургах тухай мэдүүлсэн байдаг бол Ж.Цэвээн ий дээрх бичгийн нэг онцлог тал нь “Нэгэн зүйл. Эрдэм хэмээгчид ер шавь ялгаагүй боловч жинстэн, харцас хоёрыг хамт сургах эсэхийг эртхэнээс болгоохын гуйсугай. Хэрэв хамт сургах бөгөөс албат лугаа найрсан эелдэх нэгэн сайн билээ” /5-13/ гэж хөрөнгө чинээний байдлаар үл ялгаран нэгэн гэрт сурахад болохгүй гэх газаргүй болохыг тайлбарлажээ.

Дээрх өргөн мэдүүлсэн бичгүүдийг Богд гэгээнтэн зарлигаар бататгаж ийнхүү Ж.Цэвээн ий шууд санаачилга, чин ван Ханддоржийн идэвхтэй дэмжлэгээр 1912-3-24-нд Нийслэл Хүрээнд төрийн анхны бага сургууль байгуулагдан 40 орчим хүүхэдтэй хичээллэж эхэлсэн түүхтэй. Монгол оронд шинжлэх ухааны боловсрол олгох анхны сургуулийг “Гадаад яамны байранд нээж багшаар нь Ж.Цэвээн, Гадаад яамны дэс түшмэл Лувсанжамба хоёрыг тохоон томилсон байна”. /8-335/ Энэ тухай Богдын засгийн тогтоолд “...яамны дэргэд бага сургууль байгуулах ажлыг Петербургийн их сургуулийн монгол хэлний багш Жамсрангийн Цэвээн үүсгэн санаачлав” /4-9/ гэж цохон дурджээ.

Ж.Цэвээн ий үүсгэн санаачилсан “Төрийн сургууль байгуулах тухай Буриадын эрдэмтэн Цэвээнээс Гадаад яаманд өргөсөн төслийн бичиг” /1912-3-30/, “Автономитын үеийн бага сургуулийн дүрэм” /1915-8-8/, “Автономитын үеийн дунд сургуулийг дүрэм” /1915-8-18/ зэрэг нь тухайн үеийн Монголын соёл боловсрол, сурган хүмүүжүүлэх ажлын байдал, хандлагыг үзүүлсэн үнэтэй өв, чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Өөрийн санаачилсан сургуульд суралцах хүүхдийн унших ном, бичих дэвтрийг Хиагт хотоос хувийнхаа мөнгөөр худалдан авчирч, авчирсан ном, сурах бичгээ орчуулахын хажуугаар ойлгоход дөхөмтэйг бодон хялбаршуулсан сурах бичиг зохион

анхны шавь нартаа багшилж байлаа. Тэрээр хүүхдүүдэд зориулан “Орчлон ертөнц, нарны аймгийн үүсэл”, “Дэлхийн тухай анхны төсөөлөл” зэрэг ном зохиосон нь олон жил хэрэглэгдэж, дараа үеийн монгол сурах бичгүүдийн гарын авлага болжээ.

Багшлахын хамт ард олныг гэгээрүүлэх ажил чухал байсан тул хүүхдүүд ба насанд хүрэгчдэд зориулан байгалийн ба нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн 100 шахам номыг орчуулахаар сонгон авч гадаадын хэлтэй хүмүүс болон буриад багш, сэхээтнүүдийг урин ажиллуулсан байна. Ж.Цэвээн ий сонгож авсан номуудыг сэдвээр нь задлан харахад, “...газар дэлхий, хүний нийгэм, байгалийн болоод нийгмийн түүхийн хөгжлийн тухай шинжлэх ухааны бодит мэдлэг монголчуудад муу байгааг сайтар харгалзан үзсэнийг гэрчилж байна. Тийм ч учраас тэрээр Монголын ард түмнийг байгаль ертөнцийн жам ёс, амьд ба амьд бус байгалийг гол хэсгүүд, хүн төрөлхтөний түүх, шинжлэх ухаан техникийн чухал ололт, хүн төрөлхтөний соёл дэвшлийн тухай шинжлэх ухааны танин мэдэхүйн төсөөлөлтэй болгох зорилго тавьсан нь” /4-12/ тодорхой мэдэгддэг.

Ж.Цэвээний санаачилгаар (?) онд монгол хүүхдүүдийг анх Эрхүү болон Тройцкосавск хотын сургуульд суралцуулахаар явуулж эхэлжээ. Тэрээр “Эрхүүд тэднийг дунд сургуульд оруулж өгөн, байр сууцаар ханган бараг л эцэг нь юм шиг хүн бүрийг халамжилж байсан” /7-440/ нь Монголын хойч үеийнхний төлөө хэрхэн санаа тавьж байсныг гэрчилнэ.

Тэр үеийн Монголд шинжлэх ухааны тодорхой салбараа мэргэжсэн багш нар ховор байсан тул Буриадаас олон багшийг урьж ирүүлэн манай орны боловсролын хөгжлийн төлөө ажиллуулж, тэд ч ах дүү монголчууддаа үнэн сэтгэлээр тусалсан билээ. Тийм ч учраас “Монголд ирж тусалсан Зөвлөлтийн анхны хүмүүсийн дотор түүхч Цэвээн Жамсрано, улс төрийн зүтгэлтэн Элбэгдорж, эмч Цэвэгтарав, багш Дашеев /Цэвэгжав/, Батхаан зэрэг олон буриад сэхээтэн байсан юм. Зөвлөлтийн мэргэжилтнүүд түүний дотор багтаж ирсэн буриад сэхээтнүүд монгол ах дүү нартаа бэрх төвөгтэй цагт их ачтай үйл хэрэг хийснийг бид бахдан бишрэн байдаг билээ” /7-442/.

Ардын засгийн үед

Ж.Цэвээн ий гардан боловсруулсан “Түмэнд тунхаглан зарлах бичиг” буюу МАН-ын анхны мөрийн хөтөлбөрт “Монгол олон аймгийн ардын эрх мэдлийг мандуулан түмэн ардын гашуун зовлонг арилгаад, энх төвшнөөр аж төрөн, бусад олон үндэсний улсуудын адил эрдэм билиг юугаан бадруулан гэгээрүүлж, улам улам боловсрон, хэм тэгш жаргацгаахыг хүснэ” /3-145/ гэж заасан байдаг.

Монголын хувсгалчид ард олныхоо эрдэм билгийг бадруулах эрхэм хэрэгт Ж.Цэвээн тэргүүтэй буриадын олон сэхээтнийг татан оролцуулсан бөгөөд тэд ч үнэнхүү сэтгэлээр идэвхийлэн зүтгэсэн юм.

Ардын засгийн газрын 1921-8-14-ний хурлаар ардын олон охид хөвгүүдийг бичиг үсэгт сургаж, олон түмний хэрэгт туслуулахын тулд сургууль танхим байгуулах хэргийг

Засгийн газар эрхлэн зохион байгуулахаар тогтжээ. Ингээд Засгийн газрын 1921-8-31-ний хурлаар “Сургуульд чухал хэрэглэгдэх судар ном, шашдир түүх зэргийг бодолхийлэн зохион үйлдэх эрдэмтэн түшмэлд Жамсрановыг томилон мөн сургуулийн хэргийг хамтатган эрхлүүлэхээр тогтсон” /3-214/ байна.

Ийнхүү Ж.Цэвээн болон түүний нөхдийн хичээл зүтгэлийн үр дүнд “1921-11-02-нд Нийслэл Хүрээнд ардын засгийн анхны бага сургууль нээгдсэн нь манай улсын түүхэнд ард түмний хүүхдийг сургах анхны сургууль” /10-7/ байлаа.

1924-2-13-нд Ардын Гэгээрлийн яам байгуулагдаж, сайдаар гүн О.Жамьян, зөвлөх түшмэлээр Ж.Цэвээн, эрхэлсэн түшмэлд Б. Эрдэнэ нарыг тохоон томилсон байна. Ардын гэгээрүүлэх яамны зөвлөхөөр ажиллаж байсны хувьд дунд сургууль байгуулах ажилд санаачилгатай оролцож, өмнө нь зохиосон бага, дунд сургуулийн дүрмээ хувьсгалын ёсонд зохицуулан дахин боловсруулж, дунд сургуульд үзэх сурах бичгүүдийг орчуулах, шинээр зохиох, багш нарын мэдлэг, заах аргыг сайжруулахад голлон анхаарч энэ ажилд тухайн үеийн сэхээтнүүдийг хамран оролцуулж байв. Олон хүний хөдөлмөрийг зөв зохион байгуулсны хүчинд 1910-аад хэвлэхээр төлөвлөсөн номнуудынхаа тал хувийг 1930 он гэхэд хэвлүүлж амжсан байлаа.

Анхны тусгай мэргэжлийн сургууль болох багшийн сургууль байгуулах ажлыг голлон зохион байгуулж, өөрөө багшилж, сурах бичиг, гарын авлага зохиох ажлыг удирдан чиглүүлж байлаа. Ийнхүү шинжлэх ухааны боловсролыг Монгол оронд анх дэлгэрүүлэн ард олныг гэгээрүүлэх их ажлыг эхлүүлж, Монголын анхны багш нарыг бэлтгэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан энэ хичээл зүтгэл нь манай сургууль боловсролын түүхэнд дурсагдах учиртай. Эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэн “Буриад Цэвээн Жамсраногийн бичсэн “Дэлхийн байдал” гэдэг гурван дэвтэр бол бүх Монголд түгж, одоо цагийн дэлхий ертөнцийг зөв ойлгоход маш их тус болсон билээ” /7-177/ гэж энэ эгэл эрхэм хүний тухай дурсан бичсэн нь бий.

Монголчууд дорно дахины сонгодог зохиолуудыг эртнээс сайн мэддэг байв. Харин өрнийн уран зохиолоос тухайлбал, И. Крыловын ёгт үлгэрүүд, Грибоедовын шүлгүүлийг монгол хүүхдүүд анх сурах бичгээсээ, томчууд “Шинэ толь” сэтгүүл, “Нийслэлийн сонин бичиг” сониноос Ж.Цэвээн ий орчуулгаар уншиж эхэлсэн юм. К. Марксын “Капитал” зохиолын 1-р ботийн 1-р хэсэг, В.И.Ленин, И.В.Сталины зохиолуудаас хэсэгчлэн, Марко Поло, Плано Карпини, Вильгельм Рубрик нарын замын тэмдэглэл, Ж.Баккочогийн “Декамерон”, Жюль Верний “Арван таван наст капитан”, Леон Кунегийн “Хөх Монголын хөх туг”, Г.И.Рамстедтийн “Уйгар улсын товч түүх” зэрэг 40 шахам зохиолыг орос, франц, герман хэлнээс орчуулж олны хүртээл болгосон билээ. Европын хэлнээс түүх,уран зохиолын том хэмжээний ном орчуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд эрдэмтэн Б.Ренчин багшийнхаа тухай “Энэ бол / Хөх Монголын хөх туг/ орос хэлнээс орчуулсан, Европ зүгийн анхны роман байсан юм. ” хэмээн үнэлжээ. Мөн “Халх журам” хууль цаазны бичиг, Лувсанданзангийн “Алтан товч”-ийг орос хэлээр орчуулж, эрдэм судлалын эргэлтэд оруулсан түүхэн гавьяатай хүн. Оросын эрдэмтэн В.А.Рязановский “Жамсрано...Халх Монголын үндэсний хууль, Буриадын олон хуулийн хэрэглэгдэхүүнд холбоотой бараг бүх мэдээллийг гаргаж тавьсан юм. Цэвээн эрхэм нь одоо хэвлэхээр бэлтгэж буй умард Монголын хууль “Халх журам”-ыг олж, тодорхойлж, орос хэлээр орчуулсан юм. ” гэжээ.

Тэрээр зөвхөн хүүхдүүдийн багш байсангүй, манай анхны шилдэг сэхээтнүүд Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Х.Гомбожав нар болон Оросын эрдэмтэн Гумилев зэрэг олон монголч эрдэмтдийн номын багш, эрдэм судлалын ажилд хөтөлсөн их бичгийн хүн байлаа.

Монголын сэтгүүл зүйн салбарыг үндэслэгч мөн

Орчуулсан зохиосон ном, сурах бичгүүдээ хэвлэх нь хамгийн чухал байв. Ж.Цэвээн ий уйгагүй хүчин чармайлт, худалдаачин Ф.Москвитиний зуучлал, Нийслэл Хүрээнд байгаа Орос улсын элчин төлөөлөгчийн дэмжлэгээр 1913 онд анх хэвлэх үйлдвэр оруулж ирсэн бөгөөд удалгүй Засгийн газрын шийдвэрээр Хэвдлэлийн газрын хороо байгуулж эрхлэгчээр нь Ж.Цэвээн ийг томилон ажиллуулжээ. Энэ хороо 1913-3-06-нд “Шинэ толь” хэмээх сэтгүүл гаргаж эхэлсэн ба 1914-8-21 хүртэл нийт 20 дугаар гарчээ. Энэ сэтгүүлдээ орчуулж бэлэн болсон, зохиосон сурах бичиг болон олон нийтэд зортулсан танин мэдүүлэх зорилготой үгүүлэл, нийтлэлүүдээ хэвлэж байсан юм.

Энэ сэтгүүл анхны дугаартаа “Олон Монголчууд нэгэнт тулгар төр байгуулж, тусгаар улс болсноос хойш элдэв номд боловсорч, яаравчлан хүчтэй, чийрэг болохыг хичээвэл зохих тул манай бичгийн хороо гадаад олон улсын хэрэглэж буй зүйл бүрийн эрдмийг товчлон бичих, олон Монголчуудын эрдэм суралцахад нэмэр болно” гэж зорилгоо тодорхой бичжээ. Дээрх сэтгүүлийн тухай Оросын эрдэмтэн В.Л.Котвич “...европ маягийн төр улсын үүсвэрийг тавих хэрэгт орос мэргэжилтнүүд хүчин зүтгэж байгаагийн нэгэн адил буриадууд боловсрол гэгээрлийн салбарт туслалцаа үзүүлж байв. Буриадуудын санаачилгаар / тухайлбал Ж.Цэвээн /, Оросын шинжлэх ухааны хэвлэх үйлдвэрийн дэмжлэгтэйгээр Өргөө хотноо европ маягийн хоёр багахан хэвлэх үйлдвэрийг монгол үсэгтэйгээр суурилуулан ...Ж.Цэвээн ий хянан тохиолдуулснаар нийгэм, утга зохиол, шинжлэх ухааны “Шинэ толь” эмхэтгэл гарч эхэлсэн” гэж бичжээ. Сэтгүүлийн эрхлэгч, орчуулагч, нийтлэлч нь Ж.Цэвээн байсан билээ. Уг сэтгүүл өргөн хүрээтэй материал нийтэлж байв. Анхны дугаарын гарчигууд нь:

- Тив дэлхий, халуун хүйтэн
- Салхи агаар, аянга цахилгаан
- Дэлхийн улс орон, засгийн газрынх нь хэлбэр
- Соёлын нүүдэл /нүүдлийн болон суурин аж төрөх ёс/
- Худалдаа тээвэр
- 1912-11-р сарын Орос Монголын найрамдлын гэрээний эх
- 1911 онд Санкт-Петербургт Монголын төлөөлөгчдийг хүлээн авсан протокол
- Дэлхийн байдал, арьстан, шашинтан гэх мэт ажээ.

Танин мэдүүлэхийг урьдал болгохын зэрэгцээ сэтгүүлийн үндсэн зорилго, сэтгүүлч хүнийхээ үүргийг ч биелүүлж аливаад шүүмжлэлтэй хандаж байсан нь доорх нийтлэлээс харагдана. Сэтгүүлийнхээ 1913оны 9-р сарын дугаарт “Монголын сайд түшмэдүүдийг тун хатуухан шүүмжлүүштэй. Албан тушаал, цол хэргэм, зэрэг дэв, цалин пүнлүү, шан харамж авдаг тэд сувьдаг шунахай аашилж, төр улсын эрх ашигт холбоогүй шаардлага тавин хүн ардыг чирэгдүүлсээр идэвх

зүтгэлийг огоорч, дайллага цайллага хийн, морь мал уралдуулж, хувийн зугаа цэнгэлийг хөөцөлдөж байна” хэмээн бичсэнийг одоо ч бодмоор.

1915-9-01-нээс “Нийслэлийн сонин бичиг” хэмээх сонин гарч эхэлсэн ба санаачлагч, эрхлэгч, нийтлэлч нь мөн л Ж.Цэвээн байсан юм. Үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөний үзэл санааг сурталчлан дэлгэрүүлэх, ард түмнээ бичиг үсэгтэй болгох, шинжлэх ухааны үнэн зөв мэдлэг олгох хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан энэ сонинд Д.Бодоо, Б.Дорж мэйрэн, Магсар хурц, Д.Сүхбаатар нар болон Оросын хувьсгалчид М.И.Кучеренко, В.Я.Кондаков нар ажиллаж байлаа.

1920-оод оноос Монголын хувьсгалчидтай тогтмол холбоотой байсан учраас хэвлэлийн ажлын их туршлагатай Ж.Цэвээн ий шууд оролцоотойгоор “Монголын үнэн” сонин Эрхүү хотноо анх хэвлэгдсэн түүхтэй.

Богдын засгийн газар түүний хичээл зүтгэлийг удаа дараа үнэлж байлаа. 1912 онд Богдын мутрын тэмдэг дарсан бичигт “...орос үсгийн сургагч Жамсранов бол сургуулийн гэрт ирснээсээ янагш сургуулийн хөвгүүдэд бичиг заан сургахад өчүүхэн ч залхууран хойргошилгүй өдөр тутам үнэн сэтгэлээр шамдан сургаж буй нь үнэхээр сайшаалтай” хэмээн дурдаад дэд зэрэг жинсээр хөхүүлэн шагнажээ. Мөн 1913 онд Богдын мутрын тэмдэг дарсан зарлигт “Манай Монгол улсын сургуулийн гэрийн орос үсгийн сургагч, буриад эрдэмтэн, түшмэл Жамсранов гэрээ бичгийн зүйл ангийг хэлэлцэн зохиох ба орос үсгээр орчуулан нийлүүлэх зэрэгт үнэн санаагаар хичээн зүтгэж явсан учир улсад туслагч гүн цол, “Эрдэнийн очир” одонгоор шагнав” гэж сайшаан дурджээ.

Монголын шинжлэх ухааны хөгжлийн төлөө

Монгол улсад шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойг 2011 онд тэмдэглэнэ. Төр түмнээ гэсэн эх оронч сэтгэлтэй төр, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэм ухааныг дээдлэх бичиг номын холч ухаантай мэргэд тухайн үеийн нам, төрийн эрхэнд байсан зарим хүмүүсийн буруу бодлогын харгуйгаар хийсэн бүтээснээ даруулж, тэр ч байтугай хэлмэгдэж явсан гашуун үнэн Монголын түүхэнд бий. Эдгээр хүмүүсийн алдаа оноо, зөв бурууг ялган салгаж авах ёстойг хүндэтгэн дээдэлж, орхих ёстойг орхиж байгаа өдгөө цагт Ж.Цэвээн ий манай Монголын төлөө хийсэн их ажил, тэр дундаа соён гэгээрүүлэх чиглэлээр сэдсэн бүтээснийг үнэн байдлаар нь өргөн олонд сэргээн мэдүүлж улмаар хүртэх ёстой алдрын зэрэгт өргөн залах цаг болсон нь улам бүр мэдрэгдэж байна.

1932-1937 онуудад Ленинград дахь ШУА-ийн Дорно дахины хүрээлэнд ажиллаж байхдаа монголын түүх, соёл, угсаатны зүй, аман зохиолын асар их хэрэглэгдхүүнийг эмхлэн цэгцэлж шинжлэх ухааны судлагдахууны хүрээнд оруулсан юм. “...Аман зохиолын энэ мэт үнэтэй чухал материалыг эрдэм шинжилгээний хүрээнд оруулсан хүмүүсийн дотроос эрдэмтэн Ж.Цэвээн, А. Руднев нарын бүтээл чухал суурийг эзэлнэ. Юуны өмнө 1908 онд нийтлүүлсэн “Монгол ардын утга зохиолын жишээ буюу “Халхын аялгуу” гэсэн монгол аман зохиолын дээж бичгийн чанартай томоохон эмхэтгэлийг

дурдаж болно” /16-6/ гэх мэтээр хойч үеийн эрдэмтэд түүнийг үнэлдэг, хүлээн зөвшөөрдөг юм.

Судар бичгийн хүрээлэнг байгуулалцсан нь

1920-оод оны дундуур манай хувьсгалчидтай холбоо тогтоон Монгол орны үйл амьдралд дахин оролцож, “Үнэн” сонины анхны дугааруудыг гаргахад хүчин зүтгэсэн болно. 1921 оны 9 сараас Дотоод яамны дэд сайдаар ажиллаж эхэлсэн үеэс О. Жамъян нартай танилцжээ. Тэрээр орчин цагийн шинжлэх ухааны байгууллагын үүрэг, зорилгын талаар “Эрдэм соёлд боловсорсон үгүй буюу боловсрол багатай учраас чийрэг улсын эрдэм соёл, чадал хүчинд ялагдаж, үндэс тасран мөхсөн ба хэл соёлоо алдсан явдал илэрхий. Шинжлэх ухааныг эс эрхэлбээс, улс урагш давшихгүй, бас улсад эрдэмтэн үгүй бол шинжлэх ухаанд мэргэжигсэд гарахгүй. Үүний тул шинжлэх ухааны анги газрыг тусгай байгуулах нь чухал... шинжлэх ухааны газар нь ганц нэг хүний тусын тулд оршин байх бус, энэ газар болбоос, харьяат улсад хязгаарлагдахаар үл барам бүх дэлхий дахинаа гус бүхий ба хүн төрөлхтөний боловсролд хувь нэмэр туслах арга болой “хэмээн /16-12/ нөхдөдөө ярьж, ойлгуулж, анхааруулж байсан бөгөөд уг санаагаа гүйцэлдүүлэхэд дэмжлэг чухал байв.

Үүний үр дүнд, 1921 оны сүүлчээр хэсэг бичиг номын хүмүүстэй санаа зорилгоо нэгтгэн, улс орныхоо хоцрогдлыг арилгах, ард түмнээ гэгээрүүлэх, бичиг үсэг, соёл боловсролтой болгохын тулд шинжлэх ухааны зүйл бүрийн салбарыг үүсгэн хөгжүүлэх тухай саналаа боловсруулж Ардын засгийн газраа өргөн мэдүүлсэн бөгөөд Засгийн газар 1921-11-9-д уг саналыг хэлэлцэн “Эрдэмт түшмэл Жамсрановоос бодолхийлэн зааварлаж, зөвлөсний дагуу Нийслэл хүрээний газар Номын хүрээлэн байгуулж олон улсын ном судар ба сургуулийн бичгүүдээс аль чухал хэрэглэгдэхийг нь өөрийн бичигт /хэл/ түүвэрлэн орчуулж, олон ардыг сурган боловсруулж, оюуныг судлуулан нэвтрүүлэхээр. . ” /11-3/ тогтсон билээ.

Засгийн газрын даалгавраар Ж.Цэвээн, О. Жамъян, Д. Дашням, Ч. Бат-Очир нар Судар бичгийн хүрээлэнгийн дүрмийг боловсруулсан бөгөөд Ж.Цэвээн, Орос, Франц, Германы шинжлэх ухааны байгууллагын дүрмийг орчуулан эх сурвалж болгон ашигласан байна.

1921-11-19 нд Засгийн газар хуралдаж, гүн О. Жамъянг эрхэлсэн сайдаар, эрдэмт түшмэл Ж.Цэвээн ийг эрдэмтэн нарийн бичгийн даргаар тохоон томилсон бөгөөд дээрх шийдвэрийг Богд гэгээн мутрын тамга даран баталгаажуулжээ.

Судар бичгийн хүрээлэнгийн анхны хурлаар ажлын үүрэг, чиглэлийг тогтоосон бөгөөд Франц, ба Европын хэлний ном судрыг уг хэлнээс нь болон орос хэлнээс орчуулах ажлыг Ж.Цэвээн д хариуцуулсан ба европын хэлнүүдээс шинжлэх ухааны хэмжээнд орчуулга хийж чадах ганц хүн нь ч байсан байх.

1921 оны сүүлчээр Судар бичгийн хүрээлэнгийн анхны гишүүдээр О.Жамъян, Ж.Цэвээн, Ч.Бат-Очир, Д.Дашням нарыг сонгосон бичиг шийтгэж үнэмлэх олгосон

түүхтэй. Өөрийн ажлын нэгэн тайланд “Миний санаачилгаар үүсгэн байгуулагдсан Судар бичгийн хүрээлэн нь миний Монгол улсад шинжлэх ухааны зүйлүүдийг ухахад хялбар болгон олны дунд тархаан дэлгэрүүлэх явдлыг залгамжлах нь болой. Энэ нь мэлзвэргүй үнэн хэрэг” гэж /14-4/ тодотгон бичсэн билээ

1924-2-11нд Судар бичгийн хүрээлэнгийн ээлжит хурлаар “Нэр томьёоны комисс”-ийг байгуулж даргаар нь Ж.Цэвээнийг сонгосон бөгөөд олон төрлийн шинжлэх ухааны үг хэллэгүүдийг Европын хэлнүүдээс. Анхлан монгол хэлнээ утга дүйцүүлэн чадварлаг буулгасан ба одоо ч хэвээр хэрэгдэгдэж байна. Бүр саяхан УИХ-ын чуулганы үеэр гишүүдэд Ж.Цэвээн ий “Төрийн эрх” үгүүллэгийг тарааж өгөхдөө “Хуулийн төслийг боловсруулах, батлахдаа хууль ёс, хэв журам, төр улсын талаар үндэсний уламжлалт үгсийн баялаг өв сангийн олон нэр томьёо, үг хэллэгийг анхааран үзэж хэрэглэнэ үү? Эдгээр нэр томьёо, үг хэллэгийг өдгөө нэгэнт өөд болсон эрдэмтэн Ж.Цэвээн энэхүү үгүүлэлдээ оновчтой зөв хэрэглэжээ” гэсэн цохолт хийсэн нь /4-26/ энэ хүний эрдэм ухааны цар хүрээг гэрчилнэ.

1921-1932 онуудад эрдэмтэн нарийн дарга бөгөөд жинхэнэ гишүүнээр ажиллаж байхдаа үүсгэсэн үйл хэргийнхээ төлөө үнэнхүү сэтгэлээр махран зүтгэж энэ байгууллагын цаашид ажиллах зам мөрийг нь чиглүүлж өгсөн юм.

“1925 оны 9-р сард СССР-ийн ШУА-ийн 200 жилийн ойн их хуралд эрдэмтэн С. Шагжийн хамт оролцон “/19-42/ өөрийн орны Судар бичгийн хүрээлэнгийн үүрэг зорилгын талаар товч танилцуулж хоёр байгууллагын хамтын ажиллагааны ач холбогдлыг тэмдэглээд, хуралд баяр хүргэсэн байдаг юм. Өөрийн үүсгэсэн Судар бичгийн хүрээлэн ба Оросын шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагааны эх суурийг тавьсан хүн бол Ж.Цэвээн мөн болно.

Эрдэм судлалын ажил

1900–аад оны эхээс Өвөр Монгол, халх Монгол, Буриадын олон нутгаар шинжилгээний ажлаар явж аман зохиол, угсаатны зүй, соёл судлалын чиглэлээр арвин их материал цуглуулсан билээ. Энэ тухай Финляндын монголч эрдэмтэн А. Д. Руднев “Тэрвээр тууль, дуу, үлгэр тун олныг цуглуулж, хэвлүүлсэн бөгөөд энэ нь үзтэл, өөр нэг ч цуглуулагчийн хийж амжаагүй, өөр аль ч ард түмний дотроос олж чадаагүй зүйлс юм” хэмээн бичжээ. Мөн нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байсан хүний хувьд аман зохиолоос гадна уран зохиол, түүх судлалын сэдвээр олон ном бичсэн юм. Энэ эрдэмтний бүтээлээс тоймлон дурдвал:

- “Монгол ардын утга зохиолын дээжис жишээ буюу халх аялгуу “1908 он
- “Азийн газар зүйн товхимол “1910 он
- “Монголын угсаатны уран зохиолын дээжис “эмхэтгэл

- “Аржи буржи хаан” “Шидэт хүүрийн үлгэр”, “Халхын цэцэн хааны домог”-ийг орос хэлээр хэвлүүлэв.
- “Бигэрмижид хааны намтрыг Аржи буржи хаанд модон хүний өгүүлсэн үлгэрүүд оршив “үлгэрийг орос хэлээр хэвлүүлэв.
- “17-р зууны үеийн Монголын он дарааллын бичиг” гэдэг номыг нь түүний хамгийн том ажил гэж үздэг.
- Хонжины дэвтрүүд
- “Монголын түүх” гурван дэвтэр
- “Монгол дахь хувьсгалт үйл хэргийн товч түүх “1926 он
- “Халх журам” гэдэг хууль зүйн том бүтээл, мөн Лувсанданзангийн “Алтан товч” зохиолыг 20 гаруй жил судалж орос хэлэнд орчуулан, олон улсын эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан билээ.
- “Дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошууд, дарьганга, Алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үүсэл, байдлын өгүүлэл “гэсэн угсаатны зүйн том үгүүлэл
- Хаант Монгол улсын үед “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйн бичиг “-ийг тэр үеийн бичгийн хүмүүстэй хамт боловсруулжээ.
- 1925онд П. К. Козловын экспедицийн Онгийн голын эх “Цагаан ушхай”, “Хар ушхай” гэдэг газраас олсон хадны бичээсийг Ж.Цэвээн тайлж орчуулсан бөгөөд тэр нь Цогт хун тайжийн гүн санаа бүхий шүлэг, хуучны сургааал бичээс /12-22/ байсныг эрдэмтэн Х. Пэрлээ нотолсон юм.

Энд түүний орчуулсан уран зохиолын болон төрөл бүрийн шинжлэх ухааны 50 гаруй ном, сурах бичгийг дурдаагүй болно.

Эрдэмтэн Ц. Дамдинсүрэн өөрийн дурдатгалын нэгэн өгүүлэлдээ “Цэвээн гуайн гавьяатай том ажил бол буриад үлгэрч нараас бичиж авсан буриад үлгэрийг орос үсгээр галиглан бичиж үлдээсэн, хэвлэсэн явдал болно” гэж онцлон бичсэн нь бий.

Эрдэмтэн С. Дулам “Буриадын эрдэмтэн Ж.Цэвээн /1880-1940/ бол буриад болон монгол ардын үлгэр домог болон аман зохиолын бусад төрлөөр үлэмж их хэрэглэгдхүүн цуглуулж эрдэм шинжилгээний хүрээнд оруулсан гавьяатай хүн юм. ... Тэрбээр Монголд ажиллаж байхдаа Монголын гэгээрэл, боловсрол, эрдэм шинжилгээний ажилд гол анхаарлаа чиглүүлж байв” гэж оновчтой бичжээ.

Монгол улсын төлөө үнэн сэтгэлээр махран зүтгэснийх нь хариуд “баруунтан” хэмээн мугуйдлан буруутгаж, түүний ажлын болон амины байрыг нэгжиж хурааж, сүйтгэсний харгуйгаар оюуны бүтээлийн нэлээд нь үрэгджээ.

Гэтэл нэрт монголч эрдэмтэн А. Д. Руднев энэ хүний тухай “...төгөлдөр их эрдэмтэй хүн дээ. Монголын соёлд даанч хайртай хүн байсан” /7-523/ гэж харамсан бичсэн нь ном сударт тэмдэглэгдэн үлджээ.

Энэ хүний амьдралын утга учир нь “Ж.Цэвээн эрдмийн ажлыг оролдохоосоо эхлээд хүсэн мөрөөдөж байсан эрхэм зүйл бол Монголд орчин цагийн шинжлэх ухааны үүр суурийг тавьж цэцэглүүлэн хөгжүүлэх явдал болж байв. Энэ бол Ж.Цэвээн ий ухамсарт амьдрал, үйл ажиллагааны гол тодорхойлогч шугам байсан” /2-14/ ба энэ нь манай монгол орны хөгжил дэвшлийн замын гол харгуй байсан юм.

Гадаадын эрдэмтэдтэй харилцсан захидлын тойм

Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа/1921-1932/ өөрийн хэвлэх үйлдвэртэй болох, номын сан, архив, музей байгуулах, экспедицийн судалгаа явуулах, гадаадын шинжлэх ухааны байгууллага, хүмүүстэй хамтын ажиллагаа тогтоох зэрэг олон чухал ажлыг гардан хийж байсан юм.

Нийгэм улс төрийн зүтгэлтэн, шинжлэх ухааны голлох эрдэмтний хувьд, гадаадын олон байгууллага, эрдэмтэдтэй захидал бичгээр харилцаж байсан ба энд тоймыг дурдвал:

Нэг. Ж.Цэвээн д захидал ирүүлсэн эрдэмтэд:

- Павлов. Н. В. / ургамал зүйч / - 2
- Ольденбург. С. Ф / дорно дахин судлаач / - 2
- Домбровский. Б. / химич / - 3
- Грумм Гржимайло / газар зүйч / -3
- Р. Эндрьюс / археологич / -1
- Рамстедт / хэл зүйч / -2
- Рязановский / түүхч / -2
- Лихтман /Рерихийн музейн ерөнхийлөгч/ -2

гэх мэт 30 -аад эрдэмтний 40 шахам захидал бидэнд үлджээ.

Хоёр. Ж.Цэвээн ий бусад эрдэмтдэд бичсэн цөөнгүй захидал байна.

- В. Л. Котвичид/ хэл зүйч / -2
- С. Ф. Ольденбургт / дорно дахин судлаач / -11
- Б. Я. Владимирцовт /хэл зүйч/-3
- Н. К. Рерихэд /зураач -2
- И. Базарт /багш / -2

гэх мэт 10 гаруй хүнд бичсэн 30 орчим захидал байна.

Эдгээр захидлууд нь эх бичвэр судлалд үнэтэй хэрэглэгдхүүн болох бөгөөд тухайн үеийн олон зүйлийн бодит үнэнийг өөртөө хадгалан, судлах эзнээ хүлээж байгаа нь ойлгомжтой. Эрдэмтэн нарийн бичгийн даргын хувьд, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг олон нийтэд таниулах ажлыг ч орхигдуулаагүй бөгөөд “1924 оны зун Ноён уулнаас Хүннү нарын булшийг малтаж олон сонин эд юмс олжээ. Археологийн тэдгээр олдворыг Ж.Цэвээн, В. И Лисовский нарын санаачилгаар Улаанбаатар хотод дэлгэн үзүүлсэн “нь /18-295/Монголын шинжлэх ухааны байгууллагын хийсэн анхны содон сонин ажил байв.

Гадаадын нэлээд эрдэм шинжилгээний байгууллагатай, тухайлбал, 1922-1925 онуудад Монголын говьд ажиллаж байсан Америкийн экспедицтэй холбоотой

байж, ажиллах нөхцөлийг нь хангах талд дэмжлэг үзүүлэхийн сацуу улсын эрх ашгийн үүднээс зохих гэрээ байгуулж байв. Энэ талаар Бельги улсын монголч эрдэмтэн Мостэрт “Миний бие энэ хүнийг хүндэлж үнэлдэг бөгөөд учир нь тэрээр эх орон нэгтэндээ төдийгүй монгол хэл, монгол судлалыг сонирхогч бүхэнд ихээхэн тус хүргэсэн цогт эх оронч бөгөөд нэртэй эрдэмтэн байлаа” /20-65/ хэмээн бичжээ.

Оросын хэд хэдэн дээд сургуулийн профессор энэ хүн Монгол улсын шинжлэх ухааны байгууллагыг үүсгэн санаачилсан шигээ нам төрийн олон салбарын ажлыг хүртээмжтэй, нягт няхуур хийж, оюуны цараа шаардсан бүхий л хүнд хүчир ажлыг нуруундаа үүрч гарсан, тухайн цаг үеийнхээ тэргүүлэх эрдэмтэн /улаан профессор/ байсныг түүх гэрчилнэ.

SUMMARY

Нэг. Аливаа улс орон шинжлэх эрдэмд мэргэжсэн хүмүүсийн хүчээр л хөгжинө гэдгийг ойлгон Автономитын үед шинжлэх ухааны мэдлэг олгох төрийн анхны сургууль байгуулах, Ардын засгийн газрын үед Номын хүрээлэн байгуулах шийдвэрийг гаргуулж чадсанаараа орчин цагийн шинжлэх ухааны байгууллага, сургуулийг үүсгэн санаачлагч мөн.

Хоёр. Монгол оронд олон жил ажиллахдаа шинжилгээ судалгааны асар их хэрэглэгдхүүн цуглуулж, судалсан, олны хүртээл болгосон, бусад орны шинжлэх ухааны байгууллага, хүмүүстэй хамтын ажиллагааны эх суурийг анхлан тавьсан, тогтмол хэвлэл, номын сан, архив, музейг зэргийг анх санаачлан бий болгосон. Судар бичгийн хүрээлэнгийн оюуны ажлын ачааг нуруундаа голлон үүрсэн, тухайн үеийнхээ шилдэг эрдэмтэн байв.

Гурав. Орос, англи, франц, төвд хэлийг сайн эзэмшсэн хүний хувьд тухайн үеийн монголчуудыг сэнхрүүлэн хүмүүжүүлэхэд амин чухал хэрэгтэй сурах бичиг, шинжлэх ухааны болон уран зохиолын ном зохиолыг Европын хэлнүүдээс анхлан орчуулж, Европын түүх, уран зохиолтой монгол уншигчдыг танилцуулсан нэрт соён гэгээрүүлэгч мөн.

Дөрөв. “Бие сэтгэлээ Монголын төлөө зориулж, нийгмийн амьдралын салаа бүрт сурсан мэдсэнээ хэрэгжүүлэн, хоцрогдсон буурай Монголыг өөд татахыг чармайж байсан Ж.Цэвээн бол тухайн үеийн оюун санааны эцэг мөн” гэсэн түүхч С. Идшинноровын дүгнэлттэй санал нэг байна.

Шинэ Монголын төр, нийгэмд хийсэн, үүсгэсэн их ажил, түүх, угсаатны зүй, аман зохиол, археологи зэрэг шинжлэх ухааны олон чиглэлээр бичсэн, орчуулсан нөр хөдөлмөрийг зүй ёсоор сэргээн эзэнтэй болгож, үнэний өндөрлөгт тавин үнэлүүлэхийн үүднээс Цэвээн судлал бүрэлдэн хөгжиж байна

РЕЗЮМЕ

Не каждому дана честь внести весомый вклад в историю своей родины.

Одним из немногих учёных, оставивших своё имя в истории Монголии в начале 20-го века, бесспорно является Цэвээн Жамсаранов. Его историческая заслуга в развитии образования, в обучении молодого поколения и народа Монголии велика. Он боролся в передовых рядах за светлое дело – образование. По его инициативе и под его руководством открылись младшие и средние школы, был основан современный научный центр Монголии. Как развитие и прогресс той или иной страны определяются уровнем научной организации страны, так и по мере развития и роста нашей страны дела и заслуги этого учёного должны быть оценены по достоинству.

НОМЗҮЙ

1. Авид, Б. Монгол үндэстний алдарт эрдэмтэн Цэвээн авгайн мэндэлсэн 104 жилийн ойг дурсах нь. “Хөлөн далай” сэтгүүл, Хайлаар. 1985
2. Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд, Эмхэтгэсэн С. Идшинноров, 1-р боть, УБ, 1997
3. Монгол улсын түүх. 5-р боть, УБ, 1997
4. Цэцэгмаа. Ж. Эрдэмтэн Ж.Цэвээн ий Монголд ажилласан он жилүүд, УБ, 1999
5. Автономитын үеийн сургууль. УБ, 1966
6. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1-р боть, 1968
7. Дамдинсүрэн. Ц, Бүрэн зохиол, 2-р боть, 2002
8. Монголын соёлын түүх. Дэд боть, УБ, 2002
9. 20-р зууны боловсрол судлал. /туршлага сургамж/. УБ, 2001
10. Даваасүрэн. Б, БНМАУ-ын ЕБС, түүний хөгжлийн хэтийн төлөв, 1979
11. “Угай бэшэг” сонин. 1991, № 01
12. “Зохион бүтээгч” сэтгүүл, 1994, № 03
13. “Дал” сонин. 2002, № 05
14. “Үнэн” сонин, 1990, №220
15. Дулам. С, Монгол аман зохиолын онол. УБ, 2007
16. Шинжлэх ухааны академийн түүхэн замнал. 2001
17. Гаадамба. С, Сампилдэндэв. Х, Монгол ардын аман зохиол, 1988
18. Монголын соёлын түүх. 3-р боть, 2003
19. “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүл, 1990
20. Роберт Рупен. 20-р зууны Монголчууд, УБ, 2000